



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/406

Алтай хот

Гэрээ шууд байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 34 дүгээр зүйлийн 34.2 дахь хэсэг, 46 дугаар зүйлийн 46.1.8 дахь заалт, Засгийн газрын 2021 оны Босго үнэ шинэчлэх тухай 124 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх Эрдэнэ сумын 320 суудалтай сургуулийн барилга, спорт заал буулгаж, шинээр барих барилгын барилгажих талбайн инженер-геологийн судалгааны ажлыг шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д Алтанзагас)-т олгосугай.

2.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж, шаардлага хангасан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан, захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтэд хяналт тавьж, тайлагнаж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д Алтанзагас)-т үүрэг болгосугай.

3.Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Г.Хурцгэрэл), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР

